

ЗАХИАЛАГЧ

СОЁЛ УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Э.СОНИНТОГОС

УХД0053

ГҮЙЦЭТГЭГЧ

“ТӨҮ СМАРТ ТМ” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Г.ГАНБАТ

**СУРГАЛТЫН ПРОГРАММ-MNUAC АППЛИКЭЙШН,
ЗАЙН СУРГАЛТЫН ПРОГРАММ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар №: СУИС/202001004

Улаанбаатар хот

Нэг талаас *Соёл урлагийн их сургууль* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *“Төү смарт ТМ” ХХК* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 04-р сарын 03-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь СУИС-ийн “Сургалтын программ-MNUAC аппликэйшн, зайн сургалтын программ” СУИС/202001004 тоот -г (цаашид “ажил” гэх) 30,000,000 /гучин сая/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлж, суурилуулж, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: 30,000,000 төгрөг.

4. Нийлүүлэгч нь “Сургалтын программ-MNUAC аппликэйшн, зайн сургалтын программ”-ийг 2020 оны 04 дүгээр сарын 03-нээс 2020 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.2. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.3. Техникийн тодорхойлолт, шаардлага;
- 5.4. Ажил гүйцэтгэх хуваарь (ирүүлсэн үе шатны ажлын хуваарь)
- 5.5. Бусад шаардлагатай баримт бичиг ;

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл (гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд), болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.


1. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

2. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

Гэрээ байгуулсан талууд:

ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ

СУИС-ийн боловсролын асуудал
эрхэлсэн тэргүүн дэд захирал

..... Ч.Алтанцэцэг

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, 6 дугаар хороо, СУИС-ийн Төв
байр.

Утас: 11-325205
РД: 5041775

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ

“Төү смарт ТМ” ХХК-ийн менежер


..... Г.Хатанбаатар

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Бага тойруу-49, Мэдээлэл
технологийн үндэсний парк, 224 тоот

Утас: 99086093
РД: 6019897

Харилцагч банкны нэр: Төрийн банк
Дансны дугаар: 343100195073